


Сэдэв: Инкотермсийн DAP нөхцөл





Нэрлэсэн газарт хүргэх

1. Худалдагч нь “бараа, бүтээгдэхүүнийг очих боомт, терминал дээр буулгаад эцсийн тээвэрлэгчид ачаалж бараа, бүтээгдэхүүн хүргэгдэн очих газарт байгаа худалдан авагчийн хүргэлт авах байршилд бараа, бүтээгдэхүүнийг буулгахад бэлэн байдлаар” хүргэх нөхцөл.
2. Очих газар – Очих боомт, терминалаас тусдаа байрших худалдан авагчийн албан байр, үйлдвэр, агуулах эсвэл бараа авах цэг гэх мэт газруудыг очих газраар сонгодог.
3. Хүргэлт авах байршил- Очих газрын тодорхой хэсгийн нарийвчилсан цэг. Тухайлахад: Худалдан авагчийн үйлдвэрийн арын хаалга гэх мэт.
4. Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг экспортлоход бэлэн болгож гаалийн бүрдүүлэлт хийх үүрэгтэй. Гэхдээ импортын гаалийн бүрдүүлэлтийг хариуцахгүй.



Худалдагч нь (1) анхдагч, үндсэн, эцсийн тээвэрлэгчтэй гэрээ байгуулж, (2) төлбөрийг нь төлж бараа бүтээгдэхүүн хүргэгдэн очих газрын худалдан авагчийн хүргэлт авах байршилд (3) буулгахад бэлэн байдлаар хүргэнэ.

Тээврийн хэрэгслүүд

Очих газрын хүргэлт авах байршил



Очих боомт, терминалаас хүргэлт авах байршилд бараа, бүтээгдэхүүнийг хүргэнэ. Буулгах үүрэггүй.

Очих газар гэдэг бараа бүтээгдэхүүн хүргэгдэн очих боомт, терминалаас тусдаа байрших худалдан авагчийн албан байр, үйлдвэр, агуулах эсвэл бараа авах цэг гэх мэт газруудыг хамруулж ойлгоно.

Хүргэлт авах байршил нь очих газрын тодорхой хэсгийн нарийвчилсан цэгийг хэлнэ. Жишээ нь: Худалдан авагч хүргэлтийг үйлдвэрийнхээ арын хаалган дээр авахаар тохирсон бол очих газар нь худалдан авагчийн үйлдвэр; харин үйлдвэрийн арын хаалга нь хүргэлт авах байршил юм.

- Эрсдэл, зардал нэг цэг дээр худалдагчаас худалдан авагч руу шилждэг.
- Талууд даатгалын үүргийг бие биенийхээ өмнө хүлээдэггүй.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг очих боомт, терминал дээр буулгаад эцсийн тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд ачаалж худалдан авагчийн хүргэлт авах байршилд тээврийн хэрэгслээс буулгахгүйгээр хүргэж өгнө.
- Бараа, бүтээгдэхүүнийг очих газар дээрх худалдан авагчийн хүргэлт авах байршилд хүргэснээр алдагдал, эвдрэл, гэмтлийн эрсдэл худалдан авагч руу шилждэг.
- Худалдагч анхдагч, үндсэн, эцсийн тээвэрлэлтийн гэрээг хийж зардлыг нь төлдөг.
- Худалдан авагч импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.
- Худалдан авагч бараа, бүтээгдэхүүнийг буулгах үүрэг хүлээдэг.

ДАР НӨХЦӨЛИЙН БУДУУВЧ ЗУРАГЛАЛ



Хүлээх үүрэг хариуцлага, зардал

ХУДАЛДАГЧ ХУДАЛДАН АВАГЧ

1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго	✓	✗
2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт	✓	✗
3. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх	✓	✗
Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих	✓	✗
Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах	✓	✗
4. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх	✓	✗
Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих	✓	✗
Үндсэн тээврийн хэрэгслээс буулгах	✓	✗
5. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч руу)- ийг гэрээлэх, төлөх	✓	✗
Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих	✓	✗
Эцсийн тээврийн хэрэгслээс буулгах	✗	✓
6. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт	✗	✓
7. Даатгал	✗	✗

DAP БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД



Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, өрсдэл	Худалдагч							Худалдан авагч			
	Бүх төрлийн тээвэр							Далайн болон дотоодын усан			
	EXW	FCA	CPT	CIP	DAT	DAP	DDP	FAS	FOB	CFR	CIF
Зардлын харьцуулсан хэмжээ	\$	\$\$	\$\$\$	\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$\$	\$\$	\$\$	\$\$\$	\$\$\$
Барааны баглаа боодол	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Барааны тэмдэглэгээ, шошго	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Экспортын зөвшөөрөл	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Ачаа дамжуулагчийн төлбөр	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Үндсэн тээвэрлэгч рүү хүргэх	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Үндсэн терминалын хураамж	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Усан онгоцонд ачуулах хураамж	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Усан тээвэр/агаарын тээвэр	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Экспортын барааг дамжуулагчийг сонгох	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Далайн даатгал	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Очих газрын терминалын хураамж	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Тээвэрлэгчийг сонгох	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Хилээр зорх шаардлагууд	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Гаалийн үзлэг шалгалтын төлбөр	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Гаалийн хураамж, татвар	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Худалдан авагч рүү хүргэх	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			
Ачааг буулгах	Худалдааны гэрээгээр зохицуулна.							Худалдааны гэрээгээр зохицуулна.			

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

